

ТОД БИЧИГЭЭРХИ ЦААЗ ХУУЛЬ ДАХИ
МОНГОЛЧУУДЫН ХЭЛНИЙ БОДОЛГЫН ТҮҮХЭНД
ХОЛБОГДОХ БАРИМТ СЭЛТЭЭС*

Ц. Шагдарсүрэн*

0. Оршил

I. Шагдарын Дондогдаш хаан (1741-1753)-ы зарлигаар гарсан *тогтоол*
хэмээх цааз хуулийн баримт

II. Халимагийн хаан Жинжилийн зарлиг (1822) дахи баримт

III. Дээрхи хоёр баримтад холбоотой зарим нэмэлт тайлбар:
Дүгнэлт

Үүний өмнө монгол дөрвөлжин хийгээд тод бичигээрхи зарлигийн зүйлд буй шашины түүхэнд холбогдох баримтыг тухайн үеийн төрийн бодолгын уламжлал хийгээд хууль цаазын үүднээс авч үзээд нэгэн өгүүлэл бичсэн бөгөөд энэ талаар түрүү түрүү үед гарсан түүхийн бүтээл дэхи үзэл баримтлал тодорхой баримт байсаар атал огоот хайхралгүй, өнгөрсөн нийгэмийн улс төрийн таалалд нийцүүлэн үндэсгүй дүгнэлт гаргасан зэрэг шинжлэх ухаанч бус хандалга байсаар ирсэн, 1990 оноос хойш гарсан түүхийн ном зохиол ч тэр эрчээрээ явсаар байгааг хөндөн ярьсан бөлгөө. Энэ удаад халимаг хаадын тод бичигээрхи удаа дараагийн зарлигт үндэсний хэл бичигээ заавал сурах тухай зүйл заалт уламжлагдан ирсэн талаар Дондогдаш, Жинжил нарын зарлигт буй баримтыг цоолдон авч танилцуулахыг зорилоо.

I. Шагдарын Дондогдаш хаан (1741-1753)-ы зарлигаар гарсан *тогтоол* хэмээх цааз хууль

1880 онд Г. Ф. Голстунский *Монголо-Ойратские законы 1640 года* хэмээх бүтээлдээ:

“Халимаг хаадын түүх”-энд тэмдэглэсэнээр Дөчин, Дөрвөний “Их цааз”-ын үргэлжлэл болгон шинээр *тогтоол* (=цааз хууль) гаргаж хуучин цааз хуулийг бүрэн төгөс болгох шаардалгатай

* Улаанбаатар дээд сургууль, Монгол Судлалын Төв

▼ Толилуулан буй энэ өгүүлэл нь тод болон дөрвөлжин бичгээр уламжлан ирсэн хуульзүйн дурсгалд холбогдох цуврал судалгааны үргэлжлэл бөгөөд эхний 1-р хэсэг нь *Acta Mongolica* сэтгүүлийн 2010 оны 10-р ботид *Монголын дөрвөлжин болон тод бичигийн дурасгал дахи шашины бодолго хийгээд хууль цаазын түүхэнд холбогдох баримт сэлтээс* гэдэг нэрээр гарсан болно [*Acta Mongolica*, (Centre for Mongol Studies, NUM), Vol. 10 (342), Улаанбаатар, 2010 [320 тал], 121-134-р тал]

Ц. Шагдарсүрэн

гэж Дондогдаш хаан үзсэн тухай тэмдэглэсэн зүйл буй хэмээжээ². Тэгээд ч Дондогдаш хааны үед гарсан *тогтоол* - хуулийг номынхоо нэмэлтэд хавсарган оруулсан байдаг.

Энэхүү тогтоол - хуульд монгол хэл бичигийн талаар дараахи заалт буй.

Тод эх нь:

... ᠑ Sayiduüdiyin küböüd mongyoldu ese sekēreküne ecegēseni yunan mori abād küböügiyini baγšidu öqči surya : Olondu taniqdaqу күмүнеi yunan qoyin : Olonki муüyai arban tabun mönggön : Küböügiyini baγšidu öqči suryaquni uridu metü : Küböüni nasun arban tabun күртеle ese sekēreküne cājitai ❖

К. Ф. Голстунский оросоор орчуулсан нь:

... 4. Если сыновья знатныхъ людей не будутъ упражняться (обучаться) въ монгольской грамотѣ, то съ отцовъ ихъ братья по трехлѣтней лошади, сыновей же отдавать для обученія учителю; съ многими известныхъ людей (братья) по трехлѣтнему барану, а съ (людей) низкаго званія (братья) по пятнадцати копѣекъ, и дѣтей ихъ отдавать, по прежнему, для обученія учителю. Если (чей-либо) сынъ не будетъ учиться до пятнадцати лѣтъ, то подлежитъ взысканію...³

Өдгөөчилөн буулгавал:

... Сайдуудын хөвгүүд **монгол**д [=монгол бичигт] эс сэхээрхүнээ [=эс сурвал^ц ш^ш] эцэгээс нь гунан морь [+торгуульд^ц ш^ш] аваад хөвгүүний нь багшид өгч сурга! Олонд танигдах хүний [+тухайд^ц ш^ш] гунан хонь [+торгуульд ав^ц ш^ш]. Олонхи муу [=энгийн хүний тухайд] арван таван мөнгө. Хөвгүүнийг нь багшид өгч сургах нь урьд [=дээр өгүүлсэн] мэт. Хөвгүүний нас арван тав хүртэл эс сэхээрхүнээ [=эс сурвал] цаазтай [=ялтай].

II. Халимагийн хаан Жинжилийн зарлиг (1822) дахи монгол хэл бичигт холбогдох заалт

Америкийн монголч эрдэмтэн, ойрод судлаач Ж. Р. Крюгер (J. R. Krueger) авгай А. М. Позднеевын цуглуулгаас Халимагийн хаан Жинжилийн 1822 оны зарлигийг тусхайлан авч судлаад англи орчуулгыг нь холбогдох тайлбарын хамт хавсаргажээ⁴. Энэхүү зарлигт бидний судлагдахуун болж буй *монгол* хэл бичигийн талаархи дараахи заалт буй.

Тод эх нь:

... ken cü yertemciyin xara күмүн монгол ном үзү, suru. Sayid zayisangyuudiyin köböüd mongyol nom umsixu biciküiyü / ülü segērkene, bāni ecigēsüni yunan temēn. köböügiyini baqšidu öqči suryu ❖

Харса күмүн монгол бичиг саг цидалар / köböügēn surya. zügēr zayisangyuud köböügēn yaruuyān beyedēn dāγād surya. Ene bāgiyini ügei yaduuyān abci asara ❖ /

² К. Ф. Голстунский, *Монголо-Ойратские законы 1640 года*, Дополнительные указы Галдань-Хунь-Тайджия и Законы, составленные для Волжскихъ Калмыковъ при Калмыцкомъ хань Дондукъ-Даши, Санктпетербургъ, 1880 [стр. 182], стр. 12.

³ К. Ф. Голстунский, *Монголо-Ойратские законы 1640 года*, Дополнительные указы Галдань-Хунь-Тайджия и Законы, составленные для Волжскихъ Калмыковъ при Калмыцкомъ хань Дондукъ-Даши, Санктпетербургъ, 1880 [стр. 182], стр. 25, 62.

⁴ John R. Krueger, *New Materials on Oirat Law and History, Part One, the Jinjil Decrees*, Central Asiatic Journal, vol. 16 (3), 1972, pp. 194-205.

Ц. Шагдарсүрэн

Olon-du taniqdaxu medētei kümünēgēsü bāni yunun mörin. Kōböügiyini baqšidu öqci suryuul. Olongki xara sādayai / kümünei mongyol biciq ülü yaryaji cidaxuna bāni arban taban mönggö ecigēsüni ab. Kōböüdiyini nom üzүүл ❖

Baqši / du mongyol nom üzүүлküi biciqtü ülü segēreqsēni bāluxudu, nasuni kemjilni arban taban nasun күртүлкү буй ❖ /

Zalxuugiyin ürēr suryuuli ese suruqsāni olon-du tomsor ügei keye ❖

Ж. Р. Крюгер профессор англиар орчуулсан нь:

Let any laymen of the world read and study Mongolian. If the sons of nobles and *zaisangs* are not attentive to reading and writing Mongolian, the fine is a three-year-old camel from the father. Turn-over his son to a teacher and teach (him).

Let commoners teach their sons Mongolian writing commensurate with opportunity and ability. *Zaisangs* especially are to teach their sons and personally assume their expenses. Use these fines to care for the poor and needy.

The fine for a man of knowledge in the public eye is a three-year-old horse. Give his son to the teacher and have him taught. The ordinary lay bowman, if he is unable to produce (evidence of ability in) Mongolian writing, levy a fine of fifteen copecks from his father. Make his sons learn to read.

When levying fines for being inattentive to writing and learning to read Mongolian with a teacher, the age limit is up to fifteen.

Humiliate (lit. make devoid of respect) in public those who did not learn (at) school by reason of laziness. ...⁵

Өдгөөчилөн буулгавал:

...Хэн ч ертөнцийн хар хүн **м о н г о л** ном үз, сур! Сайд зайсангуудын хөвгүүд монгол ном унших бичихэд үл сэхээрвэл [=үл сурвал^{ц ш}], баа нь эцэгээс нь гунан тэмээ [+торгуульд ав^{ц ш}]. Хөвгүүнийг нь багшид өгч сурга!

Харц хүн монгол бичигт хөвгүүнээ зохих чадалаараа сурга! Ялангуяа зайсангууд гаруугаа [=зардалаа^{ц ш}] биедээ даагаад хөвгүүнээ сурга! [+Эс тэгвэл^{ц ш}] энэ баа нь үгээгүү ядууг авч асар!

[+Хөвгүүнээ монгол ном, бичигт сургаагүй^{ц ш}] Олонд танигдах мэдээтэй хүнээс [+авах^{ц ш}] баа нь гунан морь [+торгуульд ав^{ц ш}]. Хөвгүүнийг нь багшид өгч сургуул! Олонхи хар **с а а д а г а й** хүний [+хөвгүүн^{ц ш}] монгол бичиг үл гаргаж чадвал баа нь арван таван мөнгө эцэгээс нь ав! Хөвгүүдийг нь ном үзүүл!

Багшид [+өгч^{ц ш}] монгол ном үзүүлэх, бичигт үл сэхээрсэнийг баалахад, насны хэмжил нь арван таван нас хүртэлхи буй.

Залхуугийн үрээр [=харгайгаар^{ц ш}] сургууль эс сурсаныг олонд тоомсоргүй хий [=хүндгүй болго^{ц ш}]!

III. Дээрхи хоёр баримтад холбоотой зарим тайлбар:

Дээрхи хоёр хэсэг бичвэрт өнөөдөрийн олон нийтийн монгол хэлний боловсролтой уялдуулан зарим нэг үгийг тайлбарлах шаардалга бий хэмээн үзэж байна.

⁵ John R. Krueger, *New Materials on Oirat Law and History, Part One: The Jinjil Decrees*, - Central Asiatic Journal, Volume XVI, Wiesbaden, 1972, [194-205], pp. 196, 200.

Ц. Шагдарсүрэн

III. 1. Дээрхи хоёр тус хууль зарлигт буй *Монгол* гэдэг нь даруй монгол бичиг гэсэн утга илэрхийлэх боловч монголчуудын хэрэглэж ирсэн олон зүйл монгол бичигийн аль нь вэ? гэдэг асуулт гарч ирнэ. Г. Ф. Голстунский үүнд анхаарч халимагт монгол бичигийг *quidma* хэмээдэг тул хуульд буй *Монголь үзүж* гэдэг нь даруй *тод монгол бичиг* гэдэг утгаар буй хэмээн үзжээ⁶.

Нэмэн тодруулах нь: Раднабадараагийн зохиосон Зая бандидын намтар “...*Сарны гэрэл*”-ийн монгол болон тод эхэд одоо бидний *тод үсэг, тод бичиг* гэх болсон бичигийг зохиосон тухайд *тодорхой үзэг* (үсэг) гэж, тодруулбал: ...*Тэр хулгана жилийн өвөл тодорхой үсэг зохион үйлэдвэй*(!)... хэмээсэн байдаг⁷.

Дээрхи эшлэлд ...*зохион үйлэдвэй*... гэдэг үгийн ард анхааруулах тэмдэг тавьсан нь дараахи учир шалтгаантай. Үүнийг товч тайлбарласу.

Энэхүү ...*зохион үйлэдвэй*... гэсэн сударын хэлний найруулгаас үүдэн монгол тод хоёр эхийг үзэхэд уг намтарыг анх төвөдөөр зохиосон, дараа нь тус тус монголчилож монгол болон тодоор сударласан гэж үзэх үндэс буй. Үүнд: төвөд өгүүлбэрийн найруулах онцлог тухайлбал: монголоор ...*зохиовой*... гэвэл бүрэн болох байтал... *зохион үйлэдвэй*... хэмээн найруулсан нь төвөдөөс үгчилэн орчуулж цаад төвөд эхдээ хоёр үг байсан тул хоёр үгээр нь орчуулсан болохыг батлана. Гэвч монгол сударын хэлээр шууд зохиосон байж болох ч эргэлзэх шалтгаан бас буй. Тухайлбал: Раднабадараагийн зохиосон “...*Сарны гэрэл*”-д барс жилээс дараагийн барс жил хүртэл төвөдөөс орчуулсан 200 шахам номын нэрийн жагсаалтыг үзвэл хоёр эхэд зөрөөтэй зүйл цөөнгүй, түүний учир шалтгааныг хайвал монгол намтарт тухайн ном зохиолыг зүүн монгол болон халхад орчуулсан нэрээр, тод эхэд баруун монголд орчуулсан нэрээр байгаа нь харагдана. Жишээ нь: төвөдөөр *Dri med kun ldan* гэдэг шашины утга агуулга бүхий зохиолыг Ойродын Зая бандид Намхайжамц *Хиргүй Бүхэн Төгссөн хаан* (!?) *хөвүүний тууж* гэдэг нэрээр төвөдөөс орчуулжээ. Мөн зохиолыг их орчуулагч Ширээт гүүш цорж *Хиргүй хотол төгссөн хаан хөвүүний тууж* гэдэг нэрээр тус тус орчуулсан бөлгөө. Зая бандидын намтар - “...*Сарны гэрэл*”-ийн тод эхэд уг орчуулыг *Хиргүй Бүхэн Төгссөн хаан* (!?) *хөвүүний тууж* хэмээсэн байхад монгол эхэд *Хиргүй хотол төгссөн хаан хөвүүний тууж* гэж Ширээт гүүш цоржийн орчуулгын нэрээр байдаг бөлгөө.

III. 2. Жинжилийн зарлигт “...*гаруугаа биедээ даагаад хөвгүүнээ сурга!*” гэсэн үг буй бөгөөд энэхүү *гаруу* гэдэг нь даруй ‘сүйтгэл, төлбөр’ гэсэн утга илэрхийлнэ. Эндээс монгол бичгийн хэлний *Mo. γaryu-a* гэдэг үг халхын аялгуунд *гараа*, ойрад аялгуунд *гаруу* гэж салбарлан хөгжсөн зам чийрийг илтгэх бөгөөд ийм үзэгдэл нь авиазүй болон утгазүйн учир холбогдолтой байдаг. Энэ тохиолдолд авиа-утгазүйн давхар учир холбогдол тодорхой харагдана. Харин утгазүйн хувьд хамааралгүй, (хэлшинжлэлийн хувьд Cluster / Naplology гэх зэрэг ойлголтогтой холбогдол бүхий) авиазүйн учир холбогдолоор салаалан хөгжих явдал олон байдаг бөгөөд энэ тухай зохиогч үүнээс өмнө тусгайлан нэгэн өгүүлэл бичиж нийтлүүлсэн⁸ гэдгээ дурдсу.

⁶ К. Ф. Голстунский, *Монголо-Ойратские законы 1640 года*, Дополнительные указы Галдань-Хунь-Тайджия и Законы, составленные для Волжских Калмыковъ при Калмыцкомъ хань Дондукъ-Даши, Санктпетербургъ, 1880 [стр. 182], стр. 137, 25-1 тайлбар.

⁷ Radnabhadra, *Rabjamba Čay-a bandida-yin tuyuji saran-u gerel kemekü ene metü bolai*, CSM, Tom. V, Fasc. 2, Ulan-Bator, MCMLIX, p. 12; *Biography of Čaya Pandita in oirat characters*, CSM, Tom. V, Fasc. 2-3, Ulan-Bator, 1967, [102 pp.] pp. 7, 42 (7b-8a).

⁸ Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний олон аялгуунаа үгийн хэлбэр салаалан хөгжисөн нь* (Монгол болон Алтай овогийн бусад хэлний баримт), - *Халимаг болон Монголын ойродуудын хэл аялгуу, соёлын түүхэн хэлхээ холбооны асуудалд*, Улаанбаатар, 2009, 73-86-р тал.

Ц. Шагдарсүрэн

III. 3. Жинжилийн зарлигт ...*харсаадагай* хүн... гэсэн хэлэлгэ буй бөгөөд тодоор буй энэхүү *sādayai* (< Мо. *sayadayai* < *sayaday* + *ai*) гэдэг үг зохих ёсоор анхаарал татна. Профессор Ж. Р. Крюгер (J. R. Kueger) энэ үгийг *bowman* 'харваач' хэмээн орчуулжээ. Үүнийг дараахи маягаар тодруулан тайлбарлаж болно.

Тухайн цаг үед арван зургаагаас жаран насны төрийн бүх хар хүн цэрэгийн албан хаах үүрэг бүхий байсан тул лам бус *хар* гэсэн утга илэрхийлнэ. Бүтэцийн хувьд энэ үг нь Мо. *sayaday* + *ai* гэдэг нийлмэл бүтэцтэй бөгөөд хоёрдугаар *-ai* нөхцөл нь тухайн зүйлд харьяат болохын утга санааг нэмдэг. Бидний үзэж ирсэн монгол хэлний сурах бичигт, эрт болон өдгөөгийн монгол хэлнээ харьяалахын утга бүхий *-ai* нөхцөл байдаг тухай бараг тэмдэглэж тайлбарласангүй. Гэвч энэхүү *-ai* нөхцөл халх, ойрад, буриад аялгуунаа буюу монгол хэлнээ бараг бүх нутаг оронд хэрэглэгдсээр байгаа ч учир холбогдолыг нь төдий л сайн мэдэлгүй явсаар бөлгөө. Халхад л гэхэд *Их хүрээний Вангай аймаг, Сангай аймаг, Зоогой аймаг* гэх мэтээр Их хүрээний засаг захиргааны нэгжийн нэрд байсан жишээтэй. *Манай, танай* гэдэг үгэнд ч энэхүү нөхцөл явсаар бөлгөө. Бас *Галын хаан* гэдэг нэрийг *Галай хаан* гэх нь буй. Ийм хэлбэр Жамбын "Асрагч нэрт(ийн) түүх" зэрэг монгол бичигээр хүрэлцэн ирсэн нэг бус дураасхалд

Өрсөн зөвсөн улс чинь

Өөр хүмүүнэй [=хүнийхи^{Ц.Ш.}] болон тархамзаа...

гэх мэтээр олонтаа тохиолддог.

Академич Ринчен профессор энэ нөхцөлийн талаар тусхайлан өгүүлэл бичиж *ай, аймаг* гэх зэрэг үгийн язгууртай холбоотой хэмээн үзсэн нь буй. Бас Н. Поппе профессор *Монгол хэлний харьцуулсан судлалын удирадхал* гэдэг бүтээлдээ энэ нөхцөлийн талаар дурадсан байдаг бөгөөд энэ бүхэнийг сануулан дурадсан зүйл ч гарсан билээ⁹.

III. 4. Түүхийн талаас тодруулан тайлбарлах нэгэн зүйл байна. *Монголын нууц товчоон*-ы баримтаас үзэхэд тэр үеийн Монголын төрд өнчидийг тэтгэх зорилго бүхий "авлига" хэмээх тусгай зардал байсан тухай тодорхой мэдээ гардаг. Энэчилэн бидний судлагдахуун болж буй тод бичгээрхи төр ёсны баримт буюу зарлигт

...Ялангуяа зайсангууд гаруугаа [=зардалаа^{Ц.Ш.}] биедээ даагаад хөвгүүнээ сурга! [+Эс тэгвэл^{Ц.Ш.}] энэ баа нь үгээгүү ядууг авч асар!

гэсэн заалт байдаг нь үгээгүү ядууг тэтгэх төрийн уламжлал байсныг харуулж байгаа хэрэг.

⁹ (Цаг хугацааны дараалалаар:) N. Poppe, *Introduction to Mongolian Comparative Studies*, Helsinki, 1955, [302 pp.], See pp. 190-191; Ринчен, *Нэрийн нэгэн дагаврын учир*, -Хэл зохиол судлал, Tomus XII, Fasc. II -Улаанбаатар, 1977, 35-39-р тал; Ц. Шагдарсүрэн, *XVII зууны үеийн монгол хэлийг судлах аргазүйн асуудалд* (буюу Эхбичигийн алдаа судлал)-*Монгол судлал* (МУИС-ийн Монгол хэл соёлын сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг), Боть, XXVI (226), Улаанбаатар, 2006, 133-142-р тал [Нэмэн зассан эх]

Ц. Шагдарсүрэн

Дүгнэх нь:

1. Удаа дараа гарсан хоёр зарлигт ямар ч атугай хэн боловч үндэснийхээ монгол хэл, бичигийг заавал сурах, сургах, үүнд эцэг эх нь хэн боловч анхаарах, арван таван нас хүртэлээ заавал сурсан байх, эс тэгвээс цаазтай хэмээн төрийн бодолгын төвшинд хуульчилсан гол санаа нэвт шувт хавжээ. Өөрөөр хэлбэл удаа дараагийн зарлигт уг санааг уламжлал болгосоны хажуугаар улам уламаар нарийсгасан тодруулж алхай залхууд хатуу хандсан байдал илэрхий харагдана.

2. Энэ бүхэн нь Монгол туургатаны үндэсний хэл бичиг, эх хэлний талаар төрийн хэмжээнд баримтлаж ирсэн бодолгын түүхийг тодруулахад чухаг баримт болж өгөх нь маргаангүй. Үүнээс гадна тухайн үеийн хаадын зарлиг бол өдгөөгийн ойлголтоор хууль мөний хувьд монголын хууль цаазын түүхийн судлагаанд ч үнэт хэрэглэгдэхүүн болж өгөх нь лавтай.

2010 оны 4-р сар.
Улаанбаатар хотноо.